



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/74

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын "Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт"-д дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Энхтүвшин	Орлогч дарга
Гишүүд:	Д.Ганболд	Захиргааны хэлтсийн дарга
	В.Батчимэг	Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Д.Жавхлан	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга	Б.Жаргалан	Хяналт, шинжилгээ үнэлгээ, хүнийн нөөц хариуцсан мэргэжилтэн

2. Албан хаагчдын "Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт"-д дүн шинжилгээ хийсэн тайланг 2018 оны 09 дүгээр сарын 14-ний дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Энхтүвшин/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150590741